

## ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Д.ЗОЛБОО

*Доктор (Ph.D), дэд профессор  
ШУА-ийн Олон улс судлалын  
хүрээлэнгийн захирал,*

Ийнхүү өнөөдөр манай “Олон улс судлал: 2020 – Монголын Орос судлал” хурал маань амжилттай явагдаж, үндсэн ба хавсралт илтгэлүүд тавигдлаа. Одоо хэлэлцүүлгийн хэсгээ эхлүүлье. Цайны завсарлагын үеэр манай эрдэмтэн судлаачид уулзан санал бодлоо солилцсон байх гэж бодож байна. Мөн үүнээс гадна цахимаар нийт 10 хүн оролцож байна. Ингээд асуулт хариулт байдлаар өнөөдрийн хэлэлцүүлэг явагдана.

*Доктор Р.Төрдалай:* Дэд хурандаа Н.Хүдэрбатаас асуулт асууя. Сонирхолтой илтгэл хэлэлцүүлсэн танд баярлалаа. Таны илтгэлд дурдагдсан түүхэн үечлэл дээр 1989 оноос өнөөг хүртэл гэж заагласан байна. Миний бодоход манай улсаас ОХУ-тай агаарын нисэх хүчнийг хөгжүүлэх чиглэлд харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд нэлээд эрчимжсэн учир бие даасан үечлэлд оруулж ч болохоор юм уу гэж харсан юм. 90-ээд оноос хойш нэг хэсэг хамтын ажиллагаа бага байсан шүү дээ. Тиймээс энэ үечлэлийн талаарх таны бодлыг сонсох гэсэн юм.

*Докторант, дэд хурандаа Н.Хүдэрбат:* Ерөнхийдөө манай улсад 1990-ээд оноос хойш цөөн хэдхэн онгоц орж ирсэн бөгөөд одоогоор нийтдээ ОХУ-аас оруулж ирсэн 10 орчим байлдааны онгоц, нисдэг тэрэг, тээврийн онгоц ашиглагдаж байна. Энд мөн боловсон хүчний асуудал дутмаг байгаа буюу ерөөсөө арван тав орчим хүн л ОХУ-д агаарын нисэх хүчний ангид бэлтгэгдэн төгссөн байдаг. Ийм учраас миний бие тус үечлэлийг зориуд 1989 оноос эхлүүлэн тооцсон юм. Саяхан Д.Бадрал доктор, О.Батсайхан доктортой бас энэ тухай ярилцсан. Тэгээд цаашид яг энэхүү үечлэлийг тус бүрээр нь нарийвчлан судлах шаардлагатай байгаа. Тэгж чадвал илүү үр өгөөжтэй, чухал судалгааны ажил болох болов уу гэж бодож байна. Цөөхөн тоогоор оруулж ирдгийн учир нь нууцын зэрэглэлтэй бөгөөд техник хэрэгсэл нь өндөр өртөгтэй байдагтай холбоотой. Одоогийн нөхцөлд бол хоёр улс тусламжийн хүрээнд хамтран шийдэж байгаа учир хүндрэл бага гэсэн үг. Нэг онгоцны цаана гэхэд 50 орчим сая доллар гээд тооцвол маш их зардал байгаа биз. Иймд энэ тухай зайлшгүй гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.

*Доктор Д.Дагийсүрэн:* Надад А.Даваасүрэн доктороос асуух асуулт байгаа

нь саяхан 12 дугаар сарын 15-нд болсон Хятад, Оросын удирдагчдын цахим уулзалт болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн хийсэн айлчлалтай холбоотой. Таны илтгэлд яригдсан “Сибирийн хүч-2” төслийн талаар тэдгээр үйл явдлуудад ер аль хэр хэлэлцсэн бол? Миний ойлгосноор БНХАУ-ын зүгээс цөмийн болон сэргээгдэх эрчим хүчний салбар дахь төсөл хөтөлбөрүүдээ илүүтэй дэмжин ажиллана гэснээс бус яг энэхүү хийн хоолойн асуудлаар төдийлөн байр суурь нь тодорхой харагдсангүй. Тэгэхээр энэ асуудал манай улстай холбогдох нөхцлийг та хэрхэн харж байна вэ?

*Доктор А.Даваасүрэн:* Энэ талаар бид судалгаа хийсэн. Ер нь аливаа улсын төрийн тэргүүнүүдийн ганцаарчилсан уулзалтын протокол гэж бий. Байгалийн хийн асуудлаар БНХАУ одоог хүртэл тодорхой байр суурь илэрхийлээгүй байгааг бид бүгд мэднэ. Шалтгааныг нь судлаад үзэхэд тус улс нийт хэрэглээнийхээ 40 хувийг импортоор авдгийн дотор Туркменистан, Казахстан, Тажикистан зэрэг Дундад Азийн орнууд багахан хэсгийг нь эзэлж байгаа бол үлдсэн дийлэнх хэсгийг Австрали улс эзэлдэг үзүүлэлт байна. Австрали улстай сүүлийн жилүүдэд Хятад улс ихээхэн зөрчилтэй байсан. Ерөнхийдөө Хятадын цаад бодлого нь нэг талаас өөрийн импортын зах зээлээ олшруулах эрмэлзэл, нөгөө талаас “Сибирийн хүч- 1”-ийг хэрэгжүүлсэн туршлагыг харахад Хятадын талын шууд бус хөрөнгө оруулалтаар буюу Газпромын хувьцааг худалдан авах замаар санхүүжүүлэн барьсан байдаг. Мөн мэдээж Хятад хүн үзэл бодлоо тэр даруй шууд илэрхийлэхгүй хандлагатай, тэгэхээр ийнхүү чимээгүй байгаа нь зөвшөөрөх тал руугаа ч байж магад. Үндсэндээ бидний гаргаж буй таамаглалаар бол Хятадын тал санхүүжилтыг хийх байдлаар оролцох магадлалтай гэж үзэж байгаа юм. Сая Хятад улс эрчим хүчний хямралд өртөөгүй нь нийлүүлэлтийн гэрээг нягт нямбай, тогтвортой хийж чадсанд байна. Тиймээс энэ “Сибирийн хүч-2” төсөлд Хятадын тал оролцох болон Монголын нутгаар дайруулах хүсэл байгаа гэж таамаглаж байгаа, хэрэв тэгвэл маш хямд өртгөөр баригдана шүү дээ. Гол нь хоёр талын улс төрийн шийдвэрүүд гарсны дараа хэрэгжих үндэслэлтэй болно. Одоогийн байдлаар зөвхөн ТЭЗҮ хийгдээд яваа, энэ жилдээ дуусах байх.

*Доктор Д.Дагийсүрэн:* Ерөнхий сайд нарын хамтарсан мэдэгдлийг миний бие орчуулж байхдаа анзаарахад түүн дотор бодитой тодорхой санаа харагдаагүй учир эргэлзээ төрүүлсэн. Хэдий бидний зүгээс өөдрөг төсөөлөлтэй байгаа ч хөрш хоёр улсын байр суурь, ашиг сонирхол энэ асуудал дээр нийлж байгаа эсэх нь анхаарал татаж байна л даа. Дээр нь “Бүс ба зам” санаачилга Монгол Улсад үзүүлэх нөлөө сэдэвт судалгааны хүрээнд гурван улсын Эдийн засгийн коридорын төслийн хэрэгжилтийг судалж үзэхэд төслийн эхний таван жилийн хугацаа дууссан ч одоо хэр нь яриа хэлэлцээнийхээ шатнаас гараагүй байдалтай. Гэтэл бусад улс орнуудтай хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт хурдацтай яваад байдаг. Манай талд ийнхүү удааширч буй учир юунд байна вэ?

*Доктор А.Нямдолжин:* Үүнд миний бие өөрийн бодлоо хэлье, их зөв зүйтэй

асуудал дэвшүүлж байна. Монголын газар нутгаар дамжуулан хийн хоолой тавих тухай ОХУ бараг гучаад жилийн турш ярьж ирсэн. ОХУ-ын талаас дэмжсэн ч Хятадын тал хүлээж авалгүй удсаар саяхнаас зөвшөөрөөд үйл ажиллагаа эргэн идэвхжих хандлага ажиглагдаж байгаа юм. 10 дугаар сард болсон дэлхийн 80-аад орны төр, засгийн тэргүүнүүд оролцсон Эрчим хүчний томоохон хэмжээний хурал дээр ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинээс сурвалжлагч яг энэ Сибирийн хүч-2 хийн хоолойг Монголын нутгаар дайруулан тавих асуудлын явцыг асуухад тэрээр БНХАУ-ын дарга Ши Жиньпинтэй тохиролцсон хэмээн хэлсэн. Тэгэхээр одоогоор аман тохиролцоо л хийгдсэн дүр зураг байна.

*Доктор А.Даваасүрэн:* Энд бас ОХУ-ын зүгээс маш том нэгэн болгоомжлол бий. Түүнийг арилгахын тулд томоохон наймаа хийгдэх болов уу гэж харж байна. Орос Улс хийн хоолойн талд Украин улс дээр хэрэгжүүлэх бодлогодоо том алдаа гаргасан. Учир нь үндсэн хийн хоолой Украин улсаар дамжиж байсан ч 2014 оноос хойш хаагдсан тул өнөөдөр тэд Серб улсаас авч байгаа. Манай улсын хувьд улс төрийн тогтворгүй байдал маш ихээр нөлөөлдөг. Тиймээс том хэмжээний тулгалт манай талд мөн орж ирэх магадлалтай гэж харж байна. Монголын хоолой Украины хоолой шиг болох вий зэрэг болгоомжлол байсан ч тийм зүйл болохгүй, сарын дотор барих боломжтой гэж Газпромын зүгээс мэдэгдсэн байдаг. Ерөнхийдөө хийн хоолойн төсөл удахгүй хэрэгжинэ гэсэн таамаглалтай байгаа. Хятад судлалын судлаачдын өнцгийг энд сонирхож байна.

*Доктор Д.Базардорж:* Хятад улс импортын олон талт сувагтай болох зорилгын үүднээс болгоомжилсон байр суурьтай хандах шинж ажиглагдаж байгаа. Монголын нутгаар дамжуулах тал дээр тухайн газрын байгалийн тогтоц, бүс нутгийн орчин зэрэг хүчин зүйлээс шалтгаалсан асуудлууд бий байх.

*Доктор А.Нямдолжин:* Манай улсын хувьд хийн хоолойг өөрийн газар нутгаар дамжуулах байр сууриас хандахаас бус бусад асуудал үндсэндээ борлуулагч, хүлээн авагч хоёр талын яриа хэлэлцээний явцаас хамаарна.

*Доктор Д.Золбоо:* “Олон улс судлал - 2021: Монголын Орос судлал” эрдэм шинжилгээний хурал маань өнөөдөр техникийн бага зэргийн саатлаас үүдэлтэй бага зэрэг хоцорч эхэлсэн хэдий ч амжилттай болж өндөрлөлөө. Уламжлал ёсоор энэ жилийн хурлын эмхэтгэлийг удалгүй хэвлүүлэх болно гэдгийг дуулгаж байна. Иймд өнөөдөр хэлэлцүүлсэн өөрсдийн илтгэлүүдээ манай хүрээлэнгийн Орос судлалын салбарын холбогдох ажилтнуудад ойрын хугацаанд өгөхийг танхим болон цахимаар идэвхтэй оролцсон нийт эрдэмтэн судлаачид та бүхнээс хүсье. Та бүхэндээ баярлалаа.